



**АШУУИС**  
Ашигтөгрөгний Хяналтын Удирдлага  
1942

## АШУУИС-ИЙН ДАРХАН-УУЛ АЙМАГ САЛБАР АНАГААХ УХААНЫ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/33

Дархан сум

Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний  
Их сургуулийн Дархан-уул аймаг дахь салбар  
Анагаах ухааны сургуулийн төгсөлтийн өмнөх  
сургалтад оюутан элсүүлэх  
журам батлах тухай

Монгол Улсын Дээд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 12 дугаар зүйлийн 12.1.6 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 5.8.9, 5.9 дүгээр заалт, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 346 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”, 2023 оны 115 дугаар тогтоол “Хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэл батлах тухай”, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/540 дүгээр тушаал “Оюутан элсүүлэх журам”, 2022 оны А/207 дугаар тушаал “Ур чадварын шалгалтаар тооцох хөтөлбөрийн жагсаалт батлах тухай”, 2023 оны А/97 дугаар тушаал “Босго оноо тогтоох тухай”, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн захирлын 2023 оны А/109 тоот тушаал “Төгсөлтийн өмнөх сургалтад оюутан элсүүлэх журам”, тус сургуулийн захиргааны зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “АШУУИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургуулийн төгсөлтийн өмнөх сургалтад оюутан элсүүлэх журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, элсэгчдийг бүртгэх бүртгэлийн комиссын бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Оюутан элсүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг сургалтын албаны дарга (Б.Хандаа), элсэлтийн цахим үйл ажиллагааг хариуцан ажиллахыг эрдэм шинжилгээ, мэдээлэл технологийн албаны дарга (О.Отгонтоогоо), санхүүгийн бүртгэл, төлбөр тооцоотой холбоотой үйл ажиллагааг хариуцан ажиллахыг ахлах нягтлан бодогч (Н.Уранчимэг) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаал гарсантай холбогдуулан захирлын 2022 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн А/46 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “АШУУИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургуулийн төгсөлтийн өмнөх сургалтад оюутан элсүүлэх журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хяналт-шинжилгээ, үнэлгээний албаны дарга (Ц.Нандинсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ

Б.БАЯСГАЛАНМӨНХ



2023 A tushaal

АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН ДАРХАН-УУЛ  
АЙМАГ ДАХЬ САЛБАР АНАГААХ УХААНЫ СУРГУУЛИЙН ТӨГСӨЛТИЙН ӨМНӨХ  
СУРГАЛТАД ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

**НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

- 1.1. Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн (цаашид АШУУИС гэх) Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургуульд (цаашид Дархан АУС гэх) 2023-2024 оны хичээлийн жилд төгсөлтийн өмнөх сургалтад оюутан элсүүлэхэд Монгол Улсын Дээд боловсролын тухай хууль, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/540 дүгээр тушаал “Оюутан элсүүлэх журам”, 2022 оны А/207 дугаар тушаал “Ур чадварын шалгалтаар тооцох хөтөлбөрийн жагсаалт батлах тухай”, 2023 оны А/97 дугаар тушаал “Босго оноо тогтоох тухай”, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 346 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”, 2023 оны 115 дугаар тогтоол “Хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэл батлах тухай”, АШУУИС-ийн захирлын 2023 оны А/109 дугаар тушаалаар батлагдсан “АШУУИС-ийн төгсөлтийн өмнөх сургалтад оюутан элсүүлэх журам” болон энэхүү журмыг баримтална.
- 1.2. Элсэлтийн үйл ажиллагааг ил тод, шударга, тэгш, хүртээмжтэй зохион байгуулна.
- 1.3. Элсэлтийн журам, оюутан элсүүлэх хөтөлбөр, элсэлтийн ерөнхий шалгалт (ЭЕШ)-ын оноо тооцох болон элсэлттэй холбоотой бусад мэдээллийг сургуулийн <http://www.mnumda.edu.mn> цахим хуудсанд байршуулна.
- 1.4. АШУУИС-ийн Дархан АУС-д 2023-2024 оны хичээлийн жилд оюутан элсүүлэх хяналтын тоог АШУУИС-ийн удирдах зөвлөлөөс тогтооно.
- 1.5. Засгийн газар хоорондын болон АШУУИС, Дархан АУС-тай хамтын ажиллагааны гэрээний дагуу суралцах гадаад иргэдийг АШУУИС-ийн захирлын тушаалаар шууд элсүүлэн суралцуулж болно.

**ХОЁР. ЭЛСЭЛТИЙН КОМИСС**

- 2.1. АШУҮИС-ийн Дархан АУС-ийн захирлын тушаалаар батлагдсан элсэлтийн комисс элсэлттэй холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих, комиссын гишүүдийн ажил үүргийг хуваарилах, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, журмаар зохицуулаагүй асуудлыг хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 2.2. Элсэлтийн комиссын дарга нь сургуулийн захирал, гишүүдэд сургалтын албаны дарга, эрдэм шинжилгээ, мэдээлэл технологийн албаны дарга, арга зүйч, мэргэжилтэн, багш нар байна.
- 2.3. Элсэлтийн комисс АШУҮИС-ийн Удирдах зөвлөлөөс тогтоосон оюутан элсүүлэх хяналтын тоог баримтлан оюутан элсүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.

### **ГУРАВ. БҮРТГҮҮЛЭГЧДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

- 3.1. АШУҮИС-ийн Дархан АУС-ийн элсэлтийн цахим бүртгэлийн системд бүртгүүлсэн байх;
- 3.2. Бүрэн дунд буюу түүнээс дээш боловсролтой байх;
- 3.3. Элсэлтийн ерөнхий шалгалтын (ЭЕШ), Боловсролын үнэлгээний төвийн (БҮТ) хүчин төгөлдөр батламжтай (2021, 2022), гадаад улс орны ерөнхий боловсролын шалгалтын оноог БҮТ-өөр дүйцүүлсэн батламжтай байх;
- 3.4. Тухайн хөтөлбөрт шаардагдах хичээлийн ЭЕШ-ын үндэсний хэмжээний босго оноог хангасан байх;
- 3.5. АШУҮИС-ийн бусад салбар сургуульд байхгүй хөтөлбөрөөр зарим бүс нутгаас элсэгчдийг цахим хэлбэрээр элсүүлэх;
- 3.6. БШУ-ны сайдын 2013 оны А/79 дүгээр тушаалын 7.1 дэх хэсгийг үндэслэн дараах тохиолдолд ЭЕШ-гүй элсүүлэн суралцуулж болно. Үүнд:
  - 3.6.1. Бакалаврын дээд боловсролтой буюу дипломын голч дүн 2.8 ба түүнээс дээш голч дүнтэй, хоёр дахь дээд боловсрол эзэмшихийг хүсэгчид;
  - 3.6.2. Бакалаврын болон техникийн боловсрол эзэмшсэн иргэн дипломын хөтөлбөрт элссэн бол;
  - 3.6.3. Дипломын дээд боловсролтой иргэн, бакалаврын хөтөлбөрт шаталсан сургалтаар элсэхийг хүсэгчид;
- 3.7. Нэмэлт элсэлтийг хяналтын тоонд багтаан тодорхой мэргэжлийн хөтөлбөрөөр орон нутаг харгалзахгүйгээр ЭЕШ-ийн оноогоор жагсаан элсүүлнэ.
- 3.8. Боловсролын тухай хуулийн 48.2.6, БШУС-ын сайдын 2012 оны А/92 тоот тушаалын дагуу АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны

Сургууль хандив болон хууль бус төлбөр хураамжийг элсэлтийн үйл ажиллагааны үеэр авахгүй болно.



#### **ДӨРӨВ. ЭЛСЭХ ХҮСЭЛТ ГАРГАХ**

- 4.1. Элсэгч элсэх хүсэлтийг сургуулийн <http://www.mnums-da.edu.mn> цахим хуудсанд байрлах элсэлтийн бүртгэл, мэдээллийн цахим системд гаргах ба 06 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн бүртгэлийн систем нээгдэж, ЭЕШ-н дүн нийтэд зарлагдсан сүүлийн өдрийн 18.00 цагт хүртэл бүртгэнэ.
- 4.2. Элсэгч элсэлтийн бүртгэл, мэдээллийн цахим системд шаардлагатай хувийн мэдээллээ үнэн зөв, бүрэн гүйцэд оруулах бөгөөд дутуу, алдаатай мэдээлэл оруулснаас гарах сөрөг үр дагаврыг элсэгч өөрөө хариуцна.

#### **ТАВ. ХӨТӨЛБӨР СОНГОХ, ЭЛСҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

- 5.1. Элсэгч сургуулийн <http://www.mnums-da.edu.mn> цахим хуудсанд байрлах элсэлтийн бүртгэл мэдээллийн цахим системд БҮТ-ийн кодоор бүртгүүлэн нэвтэрч, элсэх хөтөлбөрөөс сонгон баталгаажуулах товчийг дарна.
- 5.2. Анагаахын суурь боловсрол, Эрүүл мэндийн суурь боловсролын хөтөлбөрөөр элсэгчид 06 дугаар сарын 02-ны өдрөөс ЭЕШ-н дүн нийтэд зарлагдсан сүүлийн өдрийн 18.00 цагт хүртэл хөтөлбөрөөс дараалуулан сонгож бүртгүүлнэ. (Тухайлбал 1-рт уламжлалтын их эмч, 2-рт хүний их эмч гэх мэт)
- 5.3. Анагаахын суурь боловсрол, Эрүүл мэндийн суурь боловсролын хөтөлбөрөөр элсэгчдийг ЭЕШ-ын онооны нийлбэрээр эрэмбэлэн 2023 оны 06-р сарын 21-ны 12.00 цагт дүнг нийтэд зарлана.
- 5.4. Элсэгч тогтоосон хугацаанд хөтөлбөр сонголт хийгээгүй тохиолдолд элсэхээс татгалзсанд тооцно.
- 5.5. Элсэгч нь хөтөлбөр сонголтын хураамжаа цахимаар төлснөөр баталгаажих бөгөөд төлбөрийг буцаан олгохгүй.
- 5.6. Анагаахын суурь боловсрол, Эрүүл мэндийн суурь боловсролын хөтөлбөрөөр элсэгчид ЭЕШ өгсөн тухайн хот, орон нутаг дахь хяналтын тоонд онооны жагсаалтаар өрсөлдөнө.
- 5.7. Элсэгчдийн ЭЕШ-ын хэмжээст онооны нийлбэр тэнцсэн тохиолдолд онооны хувь болон бүрэн дунд боловсролын үнэмлэхийн үнэлгээний дундаж хувийг харьцуулж шийдвэрлэнэ.

- 5.8. Анагаахын суурь боловсрол, Эрүүл мэндийн суурь боловсролын хөтөлбөрөөр хуваарь сонгосон элсэгч нь хуваариас татгалзсан, баталгаажуулалт хийгээгүй тохиолдолд хяналтын тоонд багтаан нэмэлт элсэлтийг 2023 оны 06-р сарын 22-оос 26-ны өдрүүдэд зохион байгуулж дүнг 26-ны өдрийн 17:00 цагт зарлана.
- 5.9. Цахим элсэлтийн үйл ажиллагааны үед элсэлтийн бичиг баримт хуурамчаар бүрдүүлсэнтэй холбоотой үүсэх хариуцлагыг элсэгч өөрөө хүлээнэ.
- 5.10. Шаталсан хөтөлбөрөөр элсэгчдийн өмнө сурч төгссөн сургуульд албан ёсны хүсэлт гаргаж лавлагаа, тодорхойлолтыг үндэслэн бүртгэлийг баталгаажуулна.

### **ЗУРГАА. СУРАЛЦАХ ЭРХ ОЛГОХ**

- 6.1. Тухайн орон нутгийн хяналтын тоонд багтаж хөтөлбөр сонгосон элсэгч нь 48 цагийн дотор сургалтын төлбөрийн 25 хувийг төлж, анкет бөглөн, “АШУҮИС-ийн Дархан АУС-д оюутан суралцуулах гэрээ”-г оюутны албатай байгуулснаар суралцах эрх баталгаажина.
- 6.2. Суралцах эрх цуцлагдсан тохиолдолд сургалтын төлбөрийг оюутан суралцуулах гэрээний дагуу шийдвэрлэнэ.

### **ДОЛОО. ЭЛСЭГЧДИЙГ БҮРТГЭХ**

- 7.1. Элсэгчдийн бүртгэл 2023 оны 8 дугаар сарын 3 дахь долоо хоногт нээгдэнэ. Элсэгч нь дараах бичиг баримтыг бүрдүүлж цахимаар болон биеэр ирж бүртгүүлнэ. Үүнд:
- 7.1.1. Бүрэн дунд боловсролын гэрчилгээ (хэрэв түүнээс дээш шатны боловсрол эзэмшсэн бол тухай баримт бичиг)
- 7.1.2. Сурагчийн хувийн хэрэг
- 7.1.3. Элсэлтийн ерөнхий шалгалтын онооны батламж (эх хувь)
- 7.1.4. Иргэний үнэмлэх эсвэл түүнтэй адилтгах баримт бичиг
- 7.1.5. Сүүлийн 6 сарын дотор авахуулсан цээж зураг 2 хувь (3.5x4.5)
- 7.1.6. Бүртгэлийн хураамж, энгэрийн тэмдэг, оюутны нийгмийн асуудал, уралдаан тэмцээнд зориулсан зардал - 25.000 төгрөг
- 7.1.7. Сургуулийн “Сайхан сэтгэл” эмнэлгийн үзлэг оношлогоо, шинжилгээний хөнгөлөлттэй төлбөр - 45.000 төгрөг
- 7.1.8. Бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн, бүртгүүлсэн тохиолдолд бүртгэлээс хасах бөгөөд хариуцлагыг элсэгч өөрөө хүлээнэ.

- 7.2. Бакалаврын хөтөлбөрөөр элсэгчид нь Боловсролын зээлийн сангийн Оюутны хөгжлийн зээл, буцалтгүй хөнгөлөлттэй зээлээр суралцах бол холбогдох материалыг бүрдүүлнэ.
- 7.3. Элсэгч сургалтын төлбөрийг АШУҮИС-ийн Дархан АУС-ийн ХААН БАНК дахь 5046180073 тоот дансанд тушаана.
- 7.4. Сургалтын төлбөр төлж, холбогдох бичиг баримтыг бүрдүүлсэн элсэгчдийг АШУҮИС-ийн Захирлын тушаалаар баталгаажуулна.
- 7.5. Шинэ элсэгчдэд зориулсан удиртгал хичээлийг 2023 оны 8 дугаар сарын сүүлийн 7 хоногт зохион байгуулна.
- 7.6. Шинээр элссэн оюутнууд нэгдсэн журмаар сургуулийн “Сайхан Сэтгэл” эмнэлэгт эрүүл мэндийн үзлэгт хамрагдана.
- 7.7. Элсэлтийн хяналтын тоо гүйцээгүй хөтөлбөрөөр нэмэлт элсэлт зарлах бөгөөд орон нутаг харгалзахгүй бүртгэнэ.

#### **НАЙМ. ГАДААД ЭЛСЭГЧДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

- 8.1. Төгсөлтийн өмнөх сургалтад суралцах гадаадын иргэн хүсэлтээ цахимаар гаргана.
- 8.2. Гадаад иргэн нь АШУҮИС-ийн вэб хуудсанд байршуулсан (Дархан АУС-д байршуулах) өргөдлийн маягт, эрүүл мэндийн хуудсыг бөглөж, дараах баримтын хамт илгээнэ.
  - 8.2.1. Гадаад иргэний үнэмлэх (identification card), гадаад паспорт болон түүнтэй адилтгах бичиг баримт (хүчинтэй хугацаа 3-аас дээш жил)
  - 8.2.2. Боловсролын түвшинг илтгэх диплом (гэрчилгээ), дүнгийн хавсралтыг англи эсвэл монгол хэл рүү орчуулсан орчуулгын хамт
  - 8.2.3. Анли хэлний мэдлэг, чадварыг илтгэх (TOEFL, IELTS, TOEIC зэрэг олон улсад хүлээн зөвшөөрөгдөх) баримт, монгол хэлээр суралцах бол монгол хэлний шалгалтын дүн
  - 8.2.4. Цээж зураг (3.5x4.5 хэмжээтэй, сүүлийн 3 сарын дотор авхуулсан байх)
  - 8.2.5. Эрүүл мэндийн хуудас (сэтгэцийн эмчийн дүгнэлт, HIV, HBV, HCV, TPNA, TB) шинжилгээнд сүүлийн 3 сар дотор хамрагдсан байх
- 8.3. Суралцах хүсэлт гаргасан гадаад иргэнд ажлын 10 хоногт багтаан хариуг холбогдох хаягаар хүргүүлнэ.

8.4. Суралцах эрх авсан гадаадын иргэн тухайн хичээлийн жил эхлэхээс 14 хоногийн өмнө дараах материалыг эх хувиар авчирч бүртгүүлнэ. Үүнд:

- Гадаад иргэний үнэмлэх (identification card), гадаад паспорт болон түүнтэй адилтгах бичиг баримт (хүчинтэй хугацаа 3-аас дээш жил)
- Боловсролын түвшинг илтгэх диплом (гэрчилгээ), дүнгийн хавсралтыг англи эсвэл монгол хэл рүү орчуулсан орчуулгын хамт
- Анли хэлний мэдлэг, чадварыг илтгэх (TOEFL, IELTS, TOEIC зэрэг олон улсад хүлээн зөвшөөрөгдөх) баримт, монгол хэлээр суралцах бол монгол хэлний шалгалтын дүн
- Цээж зураг (3.5x4.5 хэмжээтэй, сүүлийн 3 сарын дотор авхуулсан байх)
- Эрүүл мэндийн хуудас (сэтгэцийн эмчийн дүгнэлт, HIV, HBV, HCV, TPNA, TB) шинжилгээнд сүүлийн 3 сар дотор хамрагдсан байх
- Амь нас, эрүүл мэнд, гэнэтийн осолын даатгалд хамрагдсан баримт (Монгол улсын даатгалд заавал хамрагдсан байх)
- Сургалтын хураамж төлсөн баримт (тухайн өдрийн Монгол банкны ханшаар байх)

#### ЕС. УР ЧАДВАРЫН ШАЛГАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

9.1. Элсэлтийн ерөнхий шалгалтын хоёр дахь хичээлд дүйцүүлэн тооцох ур чадварын шалгалтын хэлбэрийг элсэлтийн комисс шийдвэрлэнэ.


9.2. Ур чадварын шалгалтыг цахимаар зохион байгуулна.

9.3. Ур чадварын шалгалтын комисс байгуулж, ур чадварын шалгалтыг зохион байгуулна.

9.4. Ур чадварын шалгалтад тухайн хөтөлбөрт тавигдах хичээл I-ийн ЭЕШ-ийн босго оноо давсан оюутныг оролцуулна.

9.5. Мэргэжлийн онцлогоос хамааруулан дараах хэлбэр, агуулгыг өргөжүүлэн тусгай ур чадварыг үнэлж болно. Үүнд:

Индекс	Хөтөлбөр	Хэлбэр	Оноо
091704	Уламжлалт анагаахын засал	• Асуумж, тест	0-100
091301	Сувилахуй	• Эсээ	0-100
091702	УАСувилахуй	• Ярилцлага	0-100
091308	Эх барихуй		0-100
091602	Эм найруулагч		0-100
091403	Лабораторийн техникч		0-100



- 9.6. Уламжлалт анагаахын засал, сувилахуй, уламжлалт анагаахын сувилахуй, эх барихуй, эм найруулагч, лабораторийн техникч хөтөлбөрөөр элсэгчдийн ур чадварын шалгалтыг 2023 оны 06-р сарын 19-20-ны өдрүүдэд цахим хэлбэрээр зохион байгуулна.
- 9.7. Дээрх хөтөлбөрүүдээр ур чадварын шалгалтын оноог эрэмбэлэн 2023 оны 06-р сарын 21-ны өдрийн 12.00 цагт дүнг зарлана.
- 9.8. Ур чадварын шалгалтын хэмжээст оноог үндэслэн тухайн мэргэжил /хөтөлбөр/-өөр элсэгчийг элсүүлнэ.
- 9.9. Ур чадварын шалгалтын үнэлгээ тооцох
- 9.9.1. Ур чадварын шалгалтыг 0-100 оноогоор аравны орны нарийвчлалтайгаар үнэлэх ба энэ нь анхдагч оноо болно.
- 9.9.2. Элсэгч тус бүрийн ур чадварын шалгалтын анхны оноонд суурилсан гүйцэтгэлийн хувь буюу шалгалтын хэмжээст оноог мэргэжил тус бүрээр дараах байдлаар гаргана. Анхны оноо А, хэмжээст оноо Х гэе. Энэ тохиолдолд шалгалтын хэмжээст оноо (Х)-г хүснэгтэд заасны дагуу харгалзах томъёогоор тооцоолно. Үүнд:

№	Анхны оноо (А)	Хэмжээст оноо (Х)	Бодох томъёо
1	0-59	200-479	
2	60-64.9	480-519	
3	65-69.9	520-559	$X=480+(A-60)*8$
4	70-74.9	560-599	
5	75-79.9	600-639	
6	80-84.9	640-679	
7	85-89.9	680-719	
8	90-94.9	720-759	
9	95-100	760-800	

- 9.10. Элсэгчийн ур чадварын шалгалтын оноо нь зөвхөн тус сургууль болон хөтөлбөрийн хувьд хүчинтэй.

#### АРАВ. БУСАД

- 10.1. АШУҮИС-ийн Дархан АУС-д оюутан элсүүлэх шаардлагыг хангаагүй боловч хичээл сонгон суралцах хүсэлт гаргасан иргэнийг “Иргэнээр суралцагч” гэж бүртгэж болно.
- 10.2. Иргэнээр суралцагч нь бүрэн дунд боловсрол эзэмшсэн иргэн байх ба тухайн хичээлийн жилд 42 хүртэл багц цагийн хичээлийг судлаж болно.




- 10.3. Иргэнээр суралцагч нь оюутны хөгжлийн зээл болон буцалтгүй тусламжид хамрагдах боломжгүй.
- 10.4. Иргэнээр суралцагч нь тус журмын гуравдугаар бүлэгт заасан шаардлагыг хангасан тохиолдолд “Оюутан”-аар бүртгэж, үргэлжлүүлэн суралцуулна.
- 10.5. Иргэнээр суралцагч нь “Оюутан”-аар бүртгэгдсэн өдрөөс эхлэн холбогдох дүрэм, журмын дагуу оюутны хөгжлийн зээл буцалтгүй тусламжид хамрагдах эрх нээгдэнэ.
- 10.6. АШУҮИС-ийн Дархан АУС-ийн оюутан элсүүлэх шаардлагыг хангасан хөгжлийн бэрхшээлтэй иргэн холбогдох хууль, тогтоол, журамд заасны дагуу сургалтын төлбөрийн санхүүгийн дэмжлэгт хамрагдах боломжтой болно.

### **АРВАН НЭГ. ЭЛСЭГЧДЭД ҮЗҮҮЛЭХ ХӨНГӨЛӨЛТ, УРАМШУУЛАЛ**

- 11.1 Монгол улсын Засгийн газрын 2021 оны 321-р тогтоолоор орон нутаг дахь төрийн өмчит их, дээд сургуульд суралцах оюутнуудад сургалтын төлбөрийн 50% -ийн хөнгөлөлт үзүүлнэ.
- 11.2 Монгол Улсын Засгийн Газрын 2022 оны 346-р тогтоолыг үндэслэн Сувилахуй, сувилагч, уламжлалт анагаах ухааны сувилагч хөтөлбөрөөр элсэгчдэд дараах хөнгөлөлтийг олгоно. Үүнд:
- 10.2.1. Элсэлтийн ерөнхий шалгалтад хими, биологийн хичээл тус бүрээр 501 ба түүнээс дээш оноо авсан бол хичээлийн жилийн эхний улирлын сургалтын төлбөрийг 100 хувь;
  - 10.2.2. 2023-2024 оны хичээлийн жилд элссэн элсэгч нь хаврын улиралд 2.5-3.0 хүртэл голч оноотой суралцсан тохиолдолд сургалтын төлбөрийн 70 хувь;
  - 10.2.3. 3.0 болон түүнээс дээш голч оноотой суралцсан тохиолдолд сургалтын төлбөрийг 100 хувь төр хариуцна.
- 11.3 Монгол улсын засгийн газрын 2018 оны 46-р тогтоолын дагуу бакалаврын хөтөлбөрөөр элсэгчид Оюутны хөгжлийн зээлд хамрагдах боломжтой бөгөөд дараах бичиг баримтуудыг бүрдүүлнэ. Үүнд:
- 11.3.1. Иргэний үнэмлэхний хуулбар
  - 11.3.2. Зээл хүссэн, эргэн төлөхөө илэрхийлсэн өргөдөл
  - 11.3.3. Элсэлтийн ерөнхий шалгалтны батламжны хуулбар

11.3.4.Төлбөрийн нэхэмжлэхийн эх хувь

11.3.5.Ирээдүйн зорилгоо тодорхойлох эссэ (зээлд хамрагдсанаар нийгэмд үзүүлэх хувь нэмэр, тухайн мэргэжлээр суралцсанаар ямар үр дүнд хүрэх талаар)



11.4 Сургуулийн тэргүүлэх чиглэлийн хүрээнд Хөдөлгөөн засалч, Уламжлалт засалч хөтөлбөрөөр суралцагчдад сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлнэ.

11.5 Хөгжлийн бэрхшээлтэй шинээр элсэгч хүсэлт гаргасан тохиолдолд Захиргааны зөвлөлөөр хэлэлцэн, сургуулийн дотуур байрны төлбөрөөс нийгмийн хариуцлагын хүрээнд 100 хувь хүртэл чөлөөлж болно.

11.6 Сургуулийн гадаад хамтын ажиллагааны хүрээнд элсэгчдэд дараах боломжууд нээлттэй байна. Үүнд:

11.6.1.Францын Мулан хотын Улаан загалмайн дэргэдэх Сувилахуйн Сургууль, Японы Жичи анагаах ухааны сургууль, Японы Мацудо сургууль, Тайландын Чанг Май сургууль, ОХУ-ын Байгалийн Анагаах Ухааны Сургууль, БНХАУ-ын Хөх хотын Анагаах Ухааны Сургуулийн оюутнуудтай хамтарсан дадлага хийх, шалгуур хангасан тохиолдолд тухайн оронд дадлагын тайлан хамгаалах боломжтой.

11.6.2.БНХАУ-ын Нанжин хотын Хятад эмнэлгийн их сургуульд Сувилагч, Эм найруулагч, Уламжлалт анагаахын сувилагч мэргэжлээр 3+1 хөтөлбөрөөр үргэлжлүүлэн суралцаж хос дипломтой төгсөх боломжтой.

11.6.3.Сувилахуй, Сувилагч мэргэжлээр суралцах хугацаандаа герман хэлний В1 түвшинг хангасан тохиолдолд Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад үргэлжлүүлэн сурч, ажиллах боломжтой.

11.6.4.Уламжлалт засалч хөтөлбөрөөр суралцагчид нь Япон улсад дадлага хийх боломжтой.

ЭЛСЭГЧДИЙН ЭЛСЭЛТИЙН ОНОО ТООЦОХ ХИЧЭЭЛ

Индекс	Хөтөлбөр	ЭЕШ 1	ЭЕШ 2	ЭЕШ-ын оноо тооцох, босго оноо	Суралцах хугацаа
<b>АНАГААХЫН СУУРЬ БОЛОВСРОЛ</b>					
091201	Хүний их эмч	Хими Математик	Биологи Физик	ЭЕШ 1, ЭЕШ 2 - ийн хөтөлбөрт тавигдах босго оноо тус бүр 410 ба түүнээс дээш байна.  (ЭЕШ 1, ЭЕШ 2- оос өндөр оноотой аль нэг хичээлийг сонгоно)	2+4 жил
091101	Шүдний их эмч	Хими Математик	Биологи Физик		2+4 жил
091701	Уламжлалт анагаахын их эмч	Хими Математик	Биологи Англи хэл		2+4 жил
091212	Хүүхдийн их эмч	Хими Математик	Биологи Физик		2+4 жил
<b>ЭРҮҮЛ МЭНДИЙН СУУРЬ БОЛОВСРОЛ</b>					
098801	Нийгмийн эрүүл мэнд судлаач	Хими Нийгэм судлал	Биологи Англи хэл	ЭЕШ 1, ЭЕШ 2 - ийн хөтөлбөрт тавигдах босго оноо тус бүр 410 ба түүнээс дээш байна.  (ЭЕШ 1, ЭЕШ 2- оос өндөр оноотой аль нэг хичээлийг сонгоно)	2+3 жил
091401	Био-Анагаах судлаач	Хими Математик	Биологи Физик		2+3 жил
091601	Эм зүйч	Хими Математик	Биологи Физик		2+3 жил
<b>БАКАЛАВРЫН БОЛОВСРОЛ</b>					
091301	Сувилахуй	Хими Математик	Ур чадвар	ЭЕШ 1 босго оноо 400, ур чадварын шалгалтын босго оноо 410-аас дээш байна.	4 жил
091308	Эх барихуй	Хими Математик	Ур чадвар		4 жил
091502	Хөдөлгөөн засалч	Хими Математик	Ур чадвар		4 жил
091704	Уламжлалт анагаахын засал	Хими Математик	Биологи Англи хэл		
<b>ДИПЛОМЫН БОЛОВСРОЛ</b>					
091301	Сувилагч	Хими Математик	Ур чадвар	Аль нэг хичээлийн босго оноо 400 ба түүнээс дээш, ур чадварын босго оноо 410 байна.	3 жил
091602	Эм найруулагч				3 жил
091702	Уламжлалт анагаахын сувилагч				3 жил
091308	Эх баригч				3 жил
091403	Лабораторийн техникч				3 жил
<b>ШАТАЛСАН СУРГАЛТ</b>					

Сувилахуй	Бага эмч, Бага эмч-Сувилагч, Сувилагч мэргэжил эзэмшсэн байна.	1 жил
Эх барихуй	Эх баригч, Эх баригч-Бага эмч, Эх баригч-Сувилагч мэргэжил эзэмшсэн байна.	1 жил
Эм зүйч	Эм найруулагч (3 жил суралцсан) мэргэжил эзэмшсэн байна.	3+3 жил



АШУУИС-ийн ДАУС-ийн захирлын  
2023 оны ...дугаар сарын ...-ны өдрийн ...  
тоот тушаалын... хавсралт



2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ШИНЭЭР ЭЛСЭГЧДИЙГ БҮРТГЭХ  
БҮРТГЭЛИЙН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Бүртгэлийн комиссын нарийн бичиг:

Б.Хандаа (Сургалтын албаны дарга)

Бүртгэлийн комиссын гишүүд:

Ж.Номин-Эрдэнэ (Эмнэлгийн хөгжлийн албаны дарга)

В.Тунгалаг (Сургалтын албаны арга зүйч)

Э.Мөнхчимэг (Сургалтын албаны арга зүйч)

Д.Ариунаа (ЭШМТА-ны номын санч)

Д.Удвал (Санхүүгийн албаны тооцооны нягтлан бодогч)

С.Хандсүрэн (Дотуур байрны багш)

М.Бат-Амгалан (ЭШМТА-ны арга зүйч)